



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/Н/84

Булган сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадамд хүрэлцэн ирэх хүндэт зочид төлөөлөгчдийн өдрийн хоолны зардалд шаардагдах 12,600,000 (арван хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрхи зардлыг Булган аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан “Байгаль орчныг хамгаалах зорилгоор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээ”-ний зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) -д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010645

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дүгээр сарын 07 ны өдрийн А/484 дугаар
захирамжийн хавсралт

“Алтаргана 2024” олон улсын XV наадамд хүрэлцэн ирэх хүндэт зочдыг өдрийн хоолоор
хангах үйлчилгээний ажлын төсөв

№	Байрлах газар	Хүний тоо	Өдөр	Нэгжийн үнэ /төгрөгөөр/	Дүн /мян.төг/
2	Өдрийн хоол	120	3	35,000	12,600,000
					12,600,000